

Хоёрдугаар бүлэг

Иргэний болон гэр бүлийн хэргийн
талаар эрхийн туслалцаа узуулэх

Долдугаар зүйл

N

Эрхийн туслалцаа узуулэх

1. Энэхуу Гэрээний заалтын дагуу хоёр талый шуух иргэний болон гэр бүлийн хэргийн талаар эрхийн туслалиаа харилцан узуулж байхаар Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд уурэг авав.

2. Тус тусын улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу иргэний болон гэр бүлийн хэргийг шийдвэрлэх эрх бүхий Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн бусад байгууллагыг Гэрээний энэ хэсэгт шуух гэсн утгаар хэрэглэнэ.

Наймдугаар зүйл

Эрхийн туслалцааны хэмжээ

Иргэний болон гэр бүлийн хэргийн талаар узуулэх эрхийн туслалцаанд гэрч, хэрэгт оролцогч нарыг асууж байцаах, хэргийн газарт үзлэг, шинжилгээ хийх зэрэг байцаан шийтгэх зарим ажиллагааг явуулах, бичиг баримтуудыг солилцох явдал хамаарна*

Есдүгээр зүйл

Харилцах журам

Энэхуу Гэрээгээр өөр журам тогтоогоогуй бол Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн шуух эрхийн туслалцаа узуулэхдээ тус тусын төвийн байгууллагаар дамжуулан харилнаж байна.

Аравдугаар зүйл

Эрхийн туслалцаа узуулэхдээ харилцах хэл

I. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн шуух эрхийн туслалцаа узуулэх асуудлаар харилцахдаа ундэний буюу орос хэд хэрэглэнэ.